



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 02 өдөр

Дугаар A/967

Арвайхээр

Г Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "в", Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 99 жил, аймаг байгуулагдсаны 89 жилийн ойн баяр наамдын хүрээнд аймгийн баяр наадмын хэв журмын асуудал хариуцсан салбар хороонд наадмын талбай орчмын автомашины түгжрэлийг сааруулах, замын хөдөлгөөний дэг журмыг хангах зорилгоор автомашины А, Б, В, Y, мотоциклийн зөвшөөрлийн хуудсыг хариуцан гаргах ажлыг зохион байгуулсугай.


2. Наадмын талбайн орчимд зорчих автомашины А, Б, В Y, мотоциклийн зөвшөөрлийн хуудасны үнэ, тоо, ширхэгийг тус тус хавсралтаар баталсугай.

3. Зөвшөөрлийн хуудас олгох ажлыг хариуцан хэрэгжүүлж, орсон орлогыг нийтийн хэв журам сахиулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд зарцуулахыг Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандaa О.Ганбат)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг баяр наадмын зохион байгуулах хорооны дарга (И.Доржсүрэн), аймгийн Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандaa О.Ганбат)-д тус тус даалгасугай.

ОРЛОГЧ

О.БАТЖАРГАЛ



011100593

Аймгийн Засаг даргын 2020 оны 07
дугаар сарын 09-ны өдрийн 17..... дугаар
захирамжийн хавсралт

АВТО МАШИН, МОТОЦИКЛИЙН ЗОРЧИХ ЗӨВШӨӨРЛИЙН
ХУУДАСНЫ ТОО

№	Зөвшөөрлийн хуудасны төрөл	Тоо ширхэг	Үнэ
1	А зөвшөөрлийн хуудас	30 ш	20000
2	Б зөвшөөрлийн хуудас	200 ш	10000
3	В зөвшөөрлийн хуудас	50 ш	10000
4	Мотоциклийн зөвшөөрлийн хуудас	20 ш	3000
5	Ү зөвшөөрлийн хуудас	10 ш	үнэгүй

-оOo-